

Эрдэм шинжилгээний өгүүлэл  
УДК 811.512.31  
DOI 10.18101/3033-1310-2024-2-23-31

## БУРИАД АЯЛГУУНЫ «ТООҔОРХОХО» ХЭМЭЭХ ХЭЛЦ ҮГИЙН УТГА, СОЁЛЫН ОНЦЛОГ

© Лувсанцэрэн Цэрэнчимэд

доктор Ph.D.

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Монгол Улс, 14191. Улаанбаатар хот, Бага Тойруу-14

Tserenchimed@msue.edu.mn

**Хураангуй.** Энэхүү өгүүлэлд буриад хэл, аялгуун дахь «тооһорхохо» (хүүхэд гаднын хүний хөл үймээнээс ая тухгүй болох) хэлц үгийн утга учир, Монголын буриадууд аман ярианд хэрхэн хэлэлцэж буйг судалсан болно. Энэ хэлцийн утгыг тайлбарлахын тулд зөвхөн хэл шинжлэлийн үүднээс авч үзэх нь хангалтгүй юм. Аливаа үндэстэн, угсаатны хэлц үг нь тэдний соёл, зан заншил, ахуй, сэтгэлгээний онцлогийг хадгалж байдаг тул хэл шинжлэл, соёл судлалын аль алиных нь хүрээнд судлах шаардлагатай байдаг. «Тооһорхохо» гэх хэлц үг нь гаднын хүний хөл үймээнээс болж ядрах зүдрэх, тухгүйтэх гэх утгатай. Тодруулбал, хүнд энергитэй (ауратай) хүн ирэхээр бага насны хүүхэд өвдөж тухгүйтэхэд хэрэглэдэг. Монголчууд бага насны хүүхдийг лын хүнээс хамгаалдаг байсан тул хүүхдийг нэг нас хүртэл нь хүнтэй хориглодог байсан. Хүүхэд өвдсөн, халуурч бүлээрсэн юм уу эсвэл уйлаад эхэлбэл "тооһорхоо" гэж хэлдэг. «Тооһорхохо» гэх үйл үгээр илэрсэн хэлцийг зөвхөн буриадад хэлэлцдэг бөгөөд монгол хэлний бусад аялгуунд «хөлсөх» гэсэн үгээр хэлэлцэнэ. Харин зарим буриад аялгуу, тухайлбал, баруун буриадууд «хүлхэхэ» гэх үгийг хэрэглэдэг. Энэ хоёр хэлц үг ижил утгатай. Эдгээр хэлцийн утга, соёлын онцлогийг судалсны үр дүн дээр дурдсан онцлог шинжийг илэрхийлж буйг нотолж байна.

**Түлхүүр үг:** хэл үг, «тооһорхохо ба хүлхэхэ», буриад хэл, буриад аялгуу, эвфемизм, бэлгэдэл, цээр, философи, угсаатны соёл.

### Для цитирования

Лувсанцэрэн Ц. Буриад аялгууны «тооһорхохо» хэмээх хэлц үгийн утга, соёлын онцлог // Буриад хэл болон уран зохиол сургуульд. 2024. Дугаар 2. Н. 23–31.

### Удиртгал

Буриад аялгуутны аман ярианд уламжлан хэлэлцэж буй, эдүгээ зарим нутагт мартагдаж байж ч мэдэх «тооһорхох» хэмээх хэлц үгийн утгыг ойлгох, соёлын онцлогийг тодруулан тайлбарлахын тул онол, хэрэглээний талаас хэдэн дараах хэдэн зүйлийг тодруулж үзэх хэрэгтэй юм. Үүнд:

- 1) «Тооһо» хэмээх үгийн толь бичиг дэх утгын тайлбар;
- 2) Монгол хэлний хэлц үгийн бүтцийн онцлог;
- 3) Тооһо — нарийн тоосны гүн ухааны ойлголт;
- 4) Тооһорхохо буюу хөлсөхтэй холбоотой монгол бэлгэдэл, цээрлэх ёсны талаас анхаарч, судлах хэрэгтэй юм.

Энэхүү үгийн утгыг тайлбар толь бичгүүдэд хэрхэн тэмдэглэснийг эхлээд авч үзье.

**Тоос (он)** — нарийн хумхи; **тоос шороо**, хорш. *Өлөн тоос; нарийн тоос; тоос болох* (юман дээр тоос суух); *тоос гарах* (тоос бий болох); *тоос хадах* (тоос дээш

ихэд бужигнан хөдлөх); *тоос манарах* (тоос дэгдэн бужигнах); *тоос татах* (тоос манаран түгэх); *хумхийн тоос* (гэрэл туяанд харагдах төдийн нарийн хумхи); *тоосон товрог* (юмны хуу арилж үгүй болохы нь) [18, с 543]


**тооһо(н)** 1. Пыль; пылинка; *тооһо татаха, тооһо бу орьюула! Не поднимай пыли*, тооһо хирэ, шорой тооһон 2. Парн. К словам *эһэ тооһон саажса, хүлһэ тооһон мелкие капельки пота*; 3. Перен. *Тооһон хүйтэн морозный туман*;

**тооһорхохо** 1. Покрываться пылью / тоос шороонд хучигдсан; 2. Перен. *Кичитсья / бардамнахь, сагсуурах*; 3. *По суеверным представлениям* сглазить ребёнка / хүүхдэд гай болох (нүдний хор оруулах) [17, с. 430]

Эрдэмтэн К.М. Черемисовын тольд: «тоосорхох буюу тооһорхохо» гэсэн үгийн шууд ба шилжсэн утгыг тайлбарлажээ. «Монгол хэлний тайлбар толь»-д «тоос, тоосрох, тоосруулах» гэсэн хоёр үгийг тайлбарласан, харин «тоосорхохо» гэсэн хэлбэр байхгүй. Үгийн бүтцийн талаас үзвэл халх аялгуунд «**тоос+рх+Ө+Ө+х**» гэж байж болох ч үг хэлцээр илэрч буй санааг тэмдэглэдэг өөр үг нь «**хөл+с+Ө+Ө+х**» юм. Энэ үгийг «**хөлсөх** — өвчтэй хүн, хүүхэд багачуудын бие гадны хөл үймээнээс шалтгаалж ая тавгүй болох» [18, с. 709] гэж тайлбарлажээ. Буриад аялгуунд «**хүлһэхэ**» ~ «**тооһорхохо**» гэсэн хэлцийн аль алийг яриа, бичигт хэрэглэнэ. Тайлбар тольд тэмдэглэсэнээр: «**хүлһэхэ** — зап. Страдать от дурного глаза нюдэнэй хүйтэнһөө үбдэхэ (*по суеверным представлениям*)» [17, с. 619] западное наречие — баруун аялгуу буюу Байгалын баруун талын аялгуунуудад хэлэлцдэг хэмээн тэмдэглэжээ. Ойрд болон халхын аялгуунд нялх балчир хүүхэд хүнээс эвгүйрхэхийг «хөлсөх» хэмээн хэлэлцэнэ.

Гүн ухааны талаас Дорнын гүн ухаан, Энэтхэгийн Вайбхашика урсгалыг баримтлагчид «Маш нарийн тоос» (ragamaṇa) -оос ертөнц үүсэж, бий болсон гэж үзсэн байдаг. Энэхүү бүтээгч эхлэлүүд нь хүнд, хөнгөн зэрэг анхдагч дөрвөн бэлгэ чанар болоод хураах, хөдөлгөх үйл үйлчлэл бүхий материаллаг элементүүд байх ажээ.

Загвар 1. Маш нарийн тоосны гүн ухааны чанар



Маш нарийн тоосны нэг чухал бэлгэ чанар, үйл бол хөдөлгөөн гэж маш нарийн тоос нь хий язгуурын ачаар байнгын хөдөлгөөнд орших дотоод идэвхтэй эхлэл мөн гэж үзсэн байна. Маш нарийн тооснууд хоорондоо холбогдсоор хурсан нарийн тоос, цаашид давхарласаар хумхын тоос үүснэ. Хуралдан өсөх энэхүү процессыг Васубанду гэжээ. Маш нарийн тоос нь дээш долоо долоогоор үржигдэж төмрийн, усны, туулайн, хонины, үхрийн, нарны гэрлийн, ... таван зуугаад бээр болой. *Туулай, хонь, үхрийн тоос* гэх мэтээр дурдсан нь эдгээр амьтны ХӨЛӨӨР БОСОХ ШОРОО ТООС-ны хэмжээгээр үлгэрлэсэн хэрэг [7, с. 33]. «Ертөнцийн эхлэл маш нарийн тоосноос үүдэлтэй» хэмээх энэ эш үзэл бол тооһорхохо буюу хөлсөх гэдэг хэлцийн язгуур нь болно. Тодруулбал, гаднаас

айлд ирсэн хүний хөлийн тоос шороогоор элдэв өвчний эх үүсвэр дамжин ирж, хүүхдийн биед өөрчлөлт оруулах үйл явцыг нэрлэн тэмдэглэсэн цогц ойлголтын гүн ухааны үндэс нь энэ болно.

Энэхүү өгүүлэлд «тооһорхохо» хэмээх хэлц үгийн утга, соёлын онцлогийг дэлгэрүүлж тайлбарлахдаа: «тооһорхохо» болон «тоос» гэсэн үг орсон хэлц үгсийн бүтэц, утга, үнэлэмжийн онцлог, «тооһорхохо» хэлц үгэнд туссан угсаатны соёлын бүрдэл хэсэг, зан үйлийн тухай гэсэн ойлголтыг хамтад нь авч үзэв.

#### Үндсэн хэсэг

#### (1) «Тооһорхохо» болон «тоос»-той холбоотой хэлц үгсийн бүтэц, утга, үнэлэмж

Монгол хэлний хэлц нэгж, хэлц үг бүтцийн хувьд дан үг, холбоо үг, өгүүлбэр цаашлаад цогцолбор, бичил эхийн хэлбэрээр чилэрч болдог. Энэ тухай эрдэмтэн М. Базаррагчаа: «Хэлний нэгжүүд цувж байрлахдаа утга санаа нь өвөрмөц шинжтэй болж тогтворждог. Үүнийг хэл шинжлэлд тогтвортой нэгжис гэнэ. Ийм тогтвортой нэгж тухайлбал, бүтээвэр, үг (холбоо үг), өгүүлбэр, цогцолбор нь тухайн ард түмний зан заншил, ахуйн болон сэтгэхүйн өвөрмөц онцлогийг гүнзгий хадгалсан байдаг» энэ нь «бүтээвэр, үг, өгүүлбэр, цогцолбор»-оор илэрнэ гэжээ [1, с. 15]. Үүнд:

#### Хүснэгт 1. Монгол хэлний хэлц үгийн бүтэц

№	Хэлний нэгжийн түвшин	Жишээ нь	
1	Цогцолбор	Юмны эзэн, сумны занги Эр өсдөг, эсгий сунадаг.	уаyum-a-yin ejen, sumu-yin janggi. er-e ösdeg, isegei sunaday.
2	Өгүүлбэр	Саваагүй нохой саранд хуцна.	sabay-a-ügei noqai saran-du qučan-a.
3	Үг	Духалзах, суунаглах	duqulja, suyunaylaqu
4	Бүтээвэр	зо-г-с (жо-г-су-) зогсох, зог тус	jo-y-su, joysuqu, joу tus

Дээр үзүүлсэн баримтаас үзэхэд бидний авч үзэж буй «тооһорхохо» буюу «хүлһэхэ» нь бүтцээрээ үгийн түвшинд хамаарах хэлц үг болно. Аливаа хэл, аялгууны үгийн сангийн бүрэлдэхүүнд ялгарах онцлог зүйл нь хэлц үгс байдаг. Тэрхүү хэлц үгс нь хэлэлцэгч ард түмний олон мянган жилийн түүхийн урт хугацааны харилцах явцад бүрэлдэн тогтсон байдаг учир тухайн үндэстний уламжлал, түүх соёл, сэтгэлгээний онцлог, зан заншлыг үеэс үед хадгалсан, гэрч болдог. Энэ талд судлаачдын санал, тайлбар төдийлөн зөрөөтэй байдаггүй.


Аль нэг хэлц үгийн утга, бүтэц, хэлбэр хэлний нэгжийн аль түвшинд харьяалагдахаас тайлбарлах зүйлийн хүрээ хязгаар харилцан адилгүй байж болно. Бидний авч үзэж буй «тооһорхохо» хэлц нь үгийн сангийн үндсэн утга өргөжин, утга шилжиж бүтсэн хэлц үг мөн. Харин угсаатны соёл, сэтгэлгээний онцлог талаас хэлц үг нь тэдний амьдралын туршлага, танин мэдэхүйн илэрхийлэл болдгийг өмнө өгүүлсэн. Монголчууд мал аж ахуй эрхлэн амьдарч ирсэн тул таван хошуу мал ба хүн, амьтан, юмсын талаар гүнзгий мэдлэг, туршлага хуримтлуулсан нь

тодорхой. Энэ тухай «...мэдлэгийн хэрээр (хэмжээ) сэтгэх болон хэл сэтгэхүйн салшгүй холбоог баталж, сав ба шим ертөнцийн хүн, амьтан, юмсыг зүйрлэх арга ухаантай болжээ» [5, с. 16] гэж тайлбарлажээ. Мөн монгол хэлний хэлц үгийг утгын орноор нь дараах байдлаар ангилсан байна. Тодруулбал:

1. Тэнгэр мандал үүсэлтэй дээдлэх утгатай.
2. Шим ертөнц үүсэлтэй хүн, амьтан, ургамал төвтэй.
3. Сав ертөнц үүсэлтэй газар төвтэй (юмсын тогтоц, төлөв байдлыг нэрлэсэн утга), ус төвтэй (ариун, арвин их байдлыг нэрлэсэн утга), байгалийн үзэгдэл төвтэй үгс, эд хэрэглэл төвтэй (гол төлөв юмсын шинжийг нэрлэсэн утга)
4. Хөдөлгөөнөөс үүсэлтэй, үйл хөдлөл заасан ихэнхдээ хүн үйлдэх утгатай хэлц үгүүд хамаарна.
5. Хийсвэр сэтгэлгээний үр дүнд үүссэн хэлц үг байна. [3, с. 125-132]

Дээр дурдсан санал, ангилалд үндэслэн, *toohorkhokho* ба *khulhekhe* гэсэн хэлц үгийн үгийн сангийн утга болон утгын орныг нэгтгэн загварчилъя.

Загвар 2. Тооһорхохо, хүлхэхэ хэлц үгийн утгын орны харьяа



Загварт үзүүлсэн хэлц үгийн утгын орон, бүтэц, үгийн сангийн утгаас тодорхой харагдаж байна. Тодруулбал, нялх, бага насны хүүхэд гаднын хүнээс бие тавгүйрхэх утгыг буриад хэл-аялгуунд сав ертөнцийн юм, үзэгдэл тоос шороотой зүйрлэсэн бол халх, ойрад аялгуунд шим ертөнц, хүний бие эртхэн (хөлөөр дамжих, олны хөл)-ээр зүйрлэн өгүүлсэн нь сонирхолтой байна. Энэ нь уг хэлц үгээр илэрхийлж буй юм, үзэгдлийн адил шинжид тулгуурлан тодорхойлж, утга шилжүүлэн хэрэглэсэн сэтгэлгээний илрэл юм.

Орчин үед хэлц үгийн судалгаа тайлбар толь бичгийн хүрээнээс хальж, хэл шинжлэлийн хүн судлал, хэлний соёлын хүрээнд үндэстний танин мэдэхүй, сэтгэлгээ, соёлын онцлогийг авч үзэх болсон. В. А. Маслова: «Хэлц үгийн нэгжүүд нь ард түмний соёлын урт хугацааны үйл явцыг тусгаж, соёлын үүсэл, тогтсон хэв шинж (стереотип), жишиг хэмжүүр (эталон), анхдагч хэв байдал (архетип)

зэргийг үеэс үед хадгалан дамжуулдаг» гэжээ [13, с. 81]. Мөн профессор В. Н. Телия «хэлний бүрэлдэхүүн дэх хэлц үг нь тухайн үндэстний онцлогийг тодорхойлдог хэл, соёлын толин тусгал юм» гэж тэмдэглэсэн байдаг. Тэгэхээр энэхүү хэлц үгийг угсаатны сэтгэлгээний стереотип, тогтсон эталон болсон гэж үзэх үндэстэй. Үүнээс үүдэн, «тоос» гэх үг бүрэлдэхүүнд нь орсон өөр хэлц үг, нийлмэл бүтцээр ямар үнэлэмж илэрдгийг товч тодруулъя.

**Жишээ нь:**

- эһэ тооһоо гээхэ (урт хугацаанд нэг газарт байсан, гэр орноосоо гараагүй удсан хүн алс газар явах, юм үзэж нүд тайлах); тооһо тоодхо (тоос шороо); тооһынь гүбихэ (зодож занчих), тооһон хүйтэн (огцом их хүйтэн, хүйтний манан)
- хорвоогийн тоос хөдөлгөх (амьд явах — чамласан утга); тоосоороо булах (*урагш түрүүлэх, ардаа орхих*); тоосонд багтах (*хамт явах, оролцох*); тоосоо өргөх (хүчин зүтгэх); тоосонд дарагдахаар тосонд дарагдсан нь дээр; тоосонд бүү хүр тосонд бүү сөр (*бүү эсэргүүц*); тоос нь газраас, тос нь дотроос; тоогдож гарсан гэвшээс<sup>1</sup> тоос болсон ном (дээр) гэх мэт хэлц үг дурдаж болно.

Эдгээр хэлц үгийн бүтцэд байгаа «тоос» гэх үгээр аливаа бохир муухай, эзэнгүй, орхигдсон гэсэн утгыг төлөөлсөн бол «тос» гэсэн үг нь амьтай, идээ ундтай гэдгийг төлөөлсөн байна. Улмаар, энэ нь муу муухай юмнаас ангид хол, сайн сайхан бүхэн дэлгэрч байхыг зүйрлэсэн утгыг илэрхийлж байна. Энд өгүүлсэн «тооһорхохо» хийгээд «тоос» гэх үг орсон хэлц үгс цөөн тохиолдолд «*урагш тэргүүлэх, гэрээс гарч юм үзэх, алс явах, ямар нэг зүйлээс дээр байх*» гэсэн эерэг үнэлэмж илэрсэн. Харин ихэнх нь: «*бусдыг идэвхгүй дагалдах, урт хугацаанд хаягдаж орхигдсон, зодож занчих, гойд ялгарах амжилт үзүүлэхгүй ч аливаа зүйлд оролцох, хамт байх, бохир муухайг тархаах*» гэсэн сөрөг үнэлэмж илэрхийлсэн эталоны шинжтэй болж, хэрэглээнд хэвшжээ. «Тоос шороо»-той холбоотой хэлц үгийн олонх нь үйл хөдлөлийн идэвхгүй, аяндаа болох, гаднын таагүй нөлөөний үр дүнгийн утга илэрхийлж буй нь анхдагч үүсэл утгын орон болон үндэстэн угсаатны сэтгэлгээний онцлог, танин мэдэхүйн туршлагатай холбоотой байна.

**(2) «Тооһорхохо» хэмээх хэлц үгэнд туссан угсаатны зан үйл, соёлын онцлог**

Орчин цагийн шинжлэх ухаанд «нээлт» гэж хэлэлцэж заншсан шинжлэх ухааны үндэстэй олон асуудал, юм үзэгдлийг монголчууд эрт дээр үеэс цээрлэх, эерүүлэх, бэлгэдэх аргаар нэрлэн, учир утгыг «нүгэл» гэх үгээр тайлж, хэлэлцсээр ирсэн. Монголчуудын цээрийн ёс утга, агуулгаараа өргөн бөгөөд түүний дотор нялх балчир хүүхэдтэй холбоотой цээрлэх ёс тодорхой байртай. Нялх хүүхдийг эрүүл саруул бойжуулах, гаднаас ирэх янз бүрийн нян, бактери, вирусээс ангид байлгахын тулд хөл хорих буюу цээр хатгаж тэмдэг тавьдаг заншил саяхныг хүртэл (1960-аад он) байв. Урьдын цагт нялх хүүхэдтэй болсон буриад айл голцуу л цээр хатгадаг байсан. Цээр хатгах гэдэг тохой хэрийн модонд алганы хэмжээтэй цагаан өнгийн бүд (даавуу) бэхлээд баруун хатавчиндаа байрлуулахыг хэлнэ. Хугацааны хувьд янз бүр хагас жилээс нэг жил хүртэл үргэлжилнэ. Нэг жил гэдэг учиртай хүүхэд хөлд орох бас даахийг нь үргээх хугацаа юм. Монголчууд «Хөлөө шороодох», «Хөлөө шороодчихвол учиртай», «Даахийг нь авахаар

<sup>1</sup>Буддын шашны ёсны таван ухааны талаар мэргэшсэн хүн, их номч.

бие нь боргоших», «*боргоших– тэсвэртэй болох, боргошсон хүүхэд*» зэргээр хэлэлцдэг. Энэ нь угтаа хүүхэд гол төлөв нэг нас хүрч хөлд орно, өөрөө явдаг болохдоо бие нь чангарч хэр баргийн юманд түүртэхээ больдогтой холбоотой. Даахь үргээх заншлын хувьд нутаг нутагт бага зэрэг ялгаа бий. Их төлөв эрэгтэй хүүхдийг 3 болон 5 насанд нь буга урамдах цагаар, эмэгтэй хүүхдийг 2 болон 4 насанд нь хөхөөн дуунаар авдаг ёстой. Буриадуудын хувьд «үендөө хүрэх» буюу 1 настай болоход нь хүү охин ялгалгүй даахийг нь авдаг байсан. Үендөө хүрэх гэдэг цаг хугацааны мөчлөгийн талаас нэрлэсэн хэлц юм. 12 сар буюу нэг жилийг нэгэн үе гэж тооцдог. Үүнтэй холбоотой нас чацуу, үе тэнгийнхнийг «*үеын нүхэд, үетэн хэритэн, үетэн сасуутан*» зэргээр хэлэлцэнэ.

Цагаан даавуугаар цээрийн тэмдэг хийхээс гадна үүдэндээ хаалганы хэмжээ бүхий дөрвөлжлөн холбосон мод тавьдаг ч ёс байсан. Энэ тухай Лодон багшийн тэмдэглэлд: «...*нялх хүүхэдтэй айл цээртэй болдог юм. Хаалганы хоёр тал (хатавч)-аас урагш хоёр мод тавиад, үзүүрийг нь өөр нэг модоор холбож тавина. Ийм хаалт хийсэн айлд хүн орох ёсгүй. Нялх хүүхэдтэй айл энэ байдлаараа нэг жил болдог сон. Хэрвээ ингэж цээр хийсэн айлд хүн орвол хүүхэд нь өвдөж, үхэж ч магадгүй гэж хэлэлцдэг байсан. Нэг жил болоход хүүхэд үендөө хүрч, үсийг нь авна. Үс авснаас хойш тэр айлын цээр тавигдаж, хүн зон орох нээлттэй болдог байжээ.*» гэж өгүүлжээ. Тэмдэглэлд өгүүлсэн цаг хугацаа 1910 оноос хойш үе, газар нутаг нь одоогийн ОХУ-ын Өвөр Байгалийн хязгаар Агын тойрог дахь буриадуудын амьдрал байдлыг өгүүлжээ [12, с. 68]. Эдгээр баримтаас «цээр тавих» зан үйлийн зорилго, агуулга нь нэг боловч илэрхийлэх хэлбэрийн талд багахан ялгаатай байсан нь харагдаж байна. Тодруулбал, зарим айл цагаан даавуу модонд уяж, жижиг туг маягийн зүйл хийж хаалганы хажуунаас бэхэлдэг байсан бол зарим нь модоор хийсэн хаалтаар тус тус илэрхийлдэг байжээ. Яагаад заавал цагаан даавуу вэ? Алсаас содон харагдах учраас уу? Цагаан өнгөний бэлгэдэл үү? Хүн төрөлхтөн, угсаатны сэтгэлгээний онцлог уу? гэх мэт олон асуулт урган гарч болно. Үүнийг нягталбал, өвөрмөц сонин хариу гарах магадтай.

Энэ мэт тэмдэг тавьсан айлд хүн орох ёсгүй. Зайлшгүй шаардлагатай бол аргал хормойлж орно. Түлш оруулж байгаагаар тэр гэрийн хүн болж цээрийг эерүүлж байгаа хэрэг болно. Энэ бүхнийг монголчууд «цээрлэх ёс» хэмээн нэрлэдэг. Монгол ухаан, аж төрөх ёс, зан үйл, сав шим ертөнц, өвөг дээдэс, ахас ихэс, ах дүү, анд нөхрөө хүндлэх ёсны илрэл болсон бичигдээгүй хууль бол цээрлэх ёс юм.

Бидний авч үзэж буй хэлц үгтэй холбоотой зан үйлийн жишээ бол хори, агын буриад буюу Монгол Улсын Дорнод аймгийн буриад сумдад (1960-аад он) байсан юм. Сүүлийн үед нийгмийн хөгжил дэвшил, суурин амьдралын соёл зэрэг зүйлийн нөлөөгөөр энэхүү цээрийн ёсыг баримталдаг, дагадаг хүн, өрх гэр цөөрсөн, одоо цагт бүр байхгүй болжээ. Монголчуудын дунд нялх хүүхэдтэй холбоотой цээрийн ёс нийтлэг зүйл бий. Тухайлбал: «Энхрий хүүхэдтэй<sup>1</sup> айл хөл хорино. Хүн ирэхэд нохой хорихдоо: *Хүүхэд энхрий, хүн буухгүй*» гэж хэлнэ [15, с. 51]. Ямар хүнд хөл хорихыг хүснэгтээр харуулъя.

<sup>1</sup> Хүүхэд тогтдоггүй (хүүхэд төрсөн ч амьдарч чадахгүй нас бараад байхыг хэлнэ).

Хүснэгт 2. Хүүхдийн цээр

№	Нялх хүүхэдтэй айл ямар тохиолдолд, хэнд хөл хорих вэ?	Энхрий хүүхдийг өөрийг нь ч бас ямар тохиолдолд хөл хорих вэ?
1	Үдэш оройн цагаар яваа хүнд	Оройн цагаар гадагш гаргахгүй
2	Холоос яваа хүнд	Хамаа бус айлд оруулахгүй
3	Согтуу хүнд	Айлд хоол идүүлэхгүй
4	Өвчтэй хүнд	Бусдын аяга бариулахгүй
5	Яс баригч <sup>1</sup> хүнд	Хүний өгсөн зүйл авхуулахгүй
		Бусдын хуучин хувцас өмсүүлэхгүй, бусдад үнсүүлэхгүй.

Монгол угсаатны хувьд нялх хүүхэдтэй айл болон, хүүхдэд хамаарах цээрлэх ёсны үндсэн агуулга, зорилго адил. Адил гэхийн учир хувь хүн, гэр бүл, хүүхэд багачуудын эрүүл мэнд, ариун цэвэр, аюулгүй өсөж торних орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байдаг юм. Гагцхүү энд буриад угсаатан ямар нэг зүйлээр тэмдэг тавьж хөл хориог илэрхийлдэг байсан бол зарим нутагт хэлдэг тогтсон хэллэг (хүүхэд *энхрий*, *хүн буухгүй*)-гэй байснаар ялгаатай байна. Энэ бол соёлыг илэрхийлэх арга, тэмдгийн зүйл юм.

Аливаа угсаатны амьдралын түүхэндээ бүтээсэн соёлын хэлбэрүүдийн нэг нь зан үйлээр илэрдэг. Үндэстэн, угсаатны хэл, аялгууны баримт дахь соёлын талаар Edward Sapir, Franz Boas, В. А. Маслова (V. A. Maslova), В. Н. Телия (V. N. Teliya) зэрэг үе үеийн судлаач чухал санал тайлбар дэвшүүлсэн байдаг. «Соёл бол хүний бие эрхтний болон оюун ухааны бүх чадвар, боломж, шинж чанарыг удамшлын бус аргаар нэг хүнээс нөгөө хүнд дамжуулж байдаг хэрэглүүр» гэжээ [4, с. 209]. Энэхүү ерөнхий ойлголтыг үндэс болговол нийгмийн янз бүрийн хүчин зүйлээс гадна цаг хугацаа өнгөрөх тусам тодорхой нэг зан үйл мартагдан орхигддогийн учир нь удамшдаггүй, дадал хэвшлээр дараагийн үед уламжилдагтай холбоотой юм. Иймээс тухайн хэлц үгийн утга, соёлын онцлогийг илэрхийлж байсан зан үйлийг хэрэгжүүлэхээ болиход тус хэлц үгийн утгын хүрээ, хэлэлцэх давтамж цөөрч, хязгаарлагдаж эхэлжээ. Өнөө цагт вирусээр үүсгэгдсэн улирлын шинжтэй ханиадны халдварыг хамгийн ихээр авдаг нь нялхас болоод бага насны хүүхдүүд байсаар л байна. Нөхцөл байдал хэвээр буюу хүний хөлөөр дамждаг нян бактери, амьсгалаар дамждаг вирусын хор нөлөөнөөс сэргийлэх ач холбогдлын хувьд энэхүү цээрлэх ёс, зан үйл ач тус буураагүй гэж хэлж болно. Өргөн хүрээгээр харвал, дэлхий нийтийг хамарсан цар тахлын жилүүдэд нэг айл байтугай улс орон, тив, дэлхийгээрээ хөл хорионд орж байсан цаг саяхан. Өнөө цагт энэ зан үйл мартагдаж эхэлсэн, баримтлахаа больсон шалтгааныг нялх хүүхэд гаднын хүнээс хөлсөх, тооһорхохо больсон гэж ойлгох нь андуу болно. Харин хотжилт, суурин амьдрал, хүн амын хэт бөөгнөрөл, нягтралаас хамаарсан даяаршлын эрин үед уламжлал, шинэчлэлийн харьцаа алдагдсаны нөлөө гэж үзэх нь зохистой. «Тооһорхохо» гэдэг хэлц үгийн хэрэглээ, соёлын онцлогийг цээрлэх ёс, угсаатны ахуй байдал, нийгмийн хөгжил дэвшлийн талаас ийнхүү тайлбарлаж болно.

<sup>1</sup> Нас барсан хүний биед хүрч, хайрцаг (авс)-т хийх үйлийг гүйцэтгэдэг хүн.

### Дүгнэлт

1. «Тооһорхохо» хэмээх хэлцийн утга, хэрэглээ, соёлын онцлогийг ажигласнаар тус хэлц нь:

- а) үндэстний сэтгэлгээ;
- б) үндэстний зан заншил;
- г) үндэстний оюуны соёл;

д) үндэстний амьдралын хэв маяг гээд олон зүйлийн илэрхийлэл болсон байдгийн нэг баталгааг эндээс харж болмоор байна. Хэрэглээний талаас «хөлсөх-хүлхэх» нь нийт монгол хэл аялгуутны дундын шинжтэй, «тооһорхохо» нь буриад аялгуутны шинжтэй, утгаараа адил нэгэн цогц ойлголтыг тэмдэглэдэг хэлцүүд ажээ. Монгол, хэл аялгууны хэлц үгийн утгын сан баялаг байдгийн тодорхой баримт энэхүү.

2. Аливаа үндэстэн, угсаатны баримталдаг цээрийн ёс бол өвөг дээдсээс уламжилсан, амнаас ам, амьдралаас амьдрал, ахуйгаас ахуйд дамжуулан өвлөж ирсэн соёл байдаг. Угсаатны амьдралын туршлагаар батлагдсан, шинжлэх ухааны зохих үндэстэй нялх хүүхдэд хамаатай тус хэлц үгийн утга, соёлын онцлогоос нүүдэлчин ардын өвөрмөц зан үйл харагдаж байна.

3. Үндэстэн, угсаатны аман хууль тодорхой цагт хязгаарлагдан хуучирч, нэгэн цагт утга, агуулга нь өргөжин баяждаг онцлогтой. Үүнийг дагаад тэрхүү зан үйл, цээрийн ёсыг тэмдэглэн нэрлэдэг хэлний нэгжийн утга, хэрэглээ ч мөн адил үгийн сангийн идэвхтэй ба идэвхгүй төлөвт шилждэг байна. Тодорхой нэг зан үйлийн хэрэглээний байдал, тэдгээрийн утга, агуулгыг илэрхийлдэг хэлний нэгж (үг, хэлц үг) -ийн хэрэглээ хоёр шууд хамааралтай байдаг ажээ.

### Литература

1. Базаррагчаа М. Монгол хэл. Улаанбаатар: Тоонот пресс принтинг, 2000.
2. Базаррагчаа М. Монгол хэлний сүегэр ба найруулбар. Улаанбаатар: МУИС пресс хэвлэх үйлдвэр, 2003. 104 х.
3. Бадамдорж Д. Монгол хэлний үгийн сангийн утга судлал. Улаанбаатар: МУИС пресс хэвлэх үйлдвэр, 2015. 320 х.
4. Бадамдорж Д. Танин мэдэхүйн утга зүйн удиртгал. Улаанбаатар: Удам соёл ХХК, 2018. 204 х.
5. Баянсан Ж. Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ. Улаанбаатар: МУИС пресс хэвлэх үйлдвэр, 2016. 227 х.
6. Баянсан Ж. Танихуйн хэл шинжлэл, хэлний соёл судлал. Монгол хэл цуврал. Боть XIV. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2022. 371 х.
7. Буддын гүн ухааны түүхээс // Философи эрхийн хүрээлэн. Улаанбаатар: Академийн хэвлэл, 1987. 126 х.
8. Дашдондов Ц. Монгол-Англи өвөрмөц хэлц, хэллэгийн толь. Улаанбаатар, 2014. 500 с.
9. Доржиев Д. Мүнөөнэй буряад хэлэн. Улаан-Үдэ: Бэлиг, 2002. 208 х.
10. Дулам С. Монгол бэлгэдэл зүй. Боть 2. Улаанбаатар, 2011. 316 х.
11. Лувсанжав Чой Орос-Монгол хэлц үгийн тайлбар толь. Улаанбаатар, 1970. 640 х.
12. Линховоин Л. Агын буряадуудай урданай ёһо заншалнууд. Улаан-Үдэ, 1999. 124 х.
13. Маслова В. А. Лингвокультурология: учебное пособие для студентов высших учебных заведений. Москва: Академия, 2001. 208 с.
14. Нямбуу Х. Монгол ёс заншлын их тайлбар толь. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК, 2023. 672 х.



15. Түдэв Л. Цээрлэл зүй. Улаанбаатар: Интерпресс ХХК, 2016. 96 х.
16. Төмөртоого Д., Энхбат Д. Монгол-Англи хэл шинжлэлийн нэр томъёоны толь. Улаанбаатар: МУИС пресс хэвлэх, 2016. 424 х.
17. Черемисов К. М. Бурятско-русский словарь. Москва: Советская энциклопедия, 1973. 804 с.
18. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр, 1996. 914 с.

2024 оны 5-дугаар сарын 6-да өгүүлэл редакцийн зөвлөлд орсон, 2024 оны 5-дугаар сарын 24-дэ шүүмж гарсан, 2024 оны 5-дугаар сарын 30-да хэвлэлд орсон.

### THE MEANING AND CULTURAL SPECIFICITY OF THE BURYAT EXPRESSION “TOOHORKHO”

*Tserenchimed Luvsantseren*

Ph.D.,

Mongolian State University of Education

14 Baga Toyruu, 14191 Ulaanbaatar, Mongolia

Tserenchimed@msue.edu.mn

*Abstract.* This article examines the meaning and cultural specificity of the expression “toohorkho” (referring to a child becoming uncomfortable due to the presence of an outsider) in the Buryat language and dialects, as well as its usage in the oral speech of Mongolian Buryats. To fully explain the meaning of this expression, it is insufficient to consider it solely from a linguistic perspective. Expressions of any nation or ethnic group preserve their culture, customs, lifestyle, and mentality, and therefore, they must be studied within both linguistic and cultural frameworks. The expression “toohorkho” means to become tired, distressed, or uncomfortable due to the commotion caused by an outsider. Specifically, it is used when a person with heavy energy (aura) arrives and causes a young child to become ill or uncomfortable. Mongolians protected young children from strangers, often isolating them from people until they were one year old. If a child became sick, feverish, or started crying, it was said they were “toohorkh.” This expression is unique to the Buryat language, while other Mongolian dialects use the word “kholsokh” for the same concept. Some Buryat dialects, particularly among Western Buryats, use the word “khulsokh.” Both expressions share the same meaning. The study of these expressions' meanings and cultural specifics confirms the distinctive features mentioned above.

*Keywords:* Expression, “toohorkho and khulsokh,” Buryat language, Buryat dialects, euphemism, symbolism, taboo, philosophy, ethnic culture.

*For citation*

Luvsantseren Tserenchimed. The Meaning and Cultural Specificity of the Buryat Expression “Toohorkho” // Buryat Language and Literature in School. 2024; 2: 23–31 (In Mong).

*The article was submitted 06.05.2024; approved after reviewing 24.05.2024; accepted for publication 30.05.2024.*